



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/69

Сүхбаатар сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.3, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 07 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."COVID-19" вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны "Зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлах, зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай" А/68 дугаар захирамжийн 1 дэх хэсэгт "...2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цаг хүртэл..." гэснийг "...2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 06:00 цаг хүртэл..." гэж өөрчилсүгэй.

2.Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Аймгийн Засаг даргын 2020 оны А/16, А/57 тоот захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулах, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" А/66 дугаар захирамжийн 5 дахь хэсгийг хүчингүйд тооцсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа, аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Баатар нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ